

# Living the

# LOTUS

## Buddhism in Everyday Life

7  
2017



VOL. 142

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ҮГ

### Өөрийгөө бүрэн зориулах нь

Бурхан багш "Номын багш" бүлэгт "Цагаан лянхуа судрын нэг мөр, нэг бадгийг ч хамаагүй сонсоод баярлах юм бол тэр хүн гарцаагүй бурханы хутгийг олж чадна гэдгийг би баталж байна" гэж амласан байдаг.

Сүсэг бишрэл гэдэг сонин зүйл шүү. Сургаалыг тийм сайн мэдэхгүй байсан ч гэсэн "баярламаар, талархмаар" гэж байнга хэлдэг хүн буян хишгийг харамгүй хүртэж чаддаг.

Гэтэл эсрэгээрээ юм бүхэнд хэт онолоор ханддаг хүн сургаал номыг маш сайн мэддэг атлаа буян хишгийг тэр болгон хүртэж чаддаггүй. Шалтгаан нь юунд байна вэ гэхээр, онол их ярьдаг хүн сэтгэл хөдлөл багатай байдаг. Тэгэхээр сургаалд хандах хандлага нь

өөр байхаас аргагүй юм.

Сургаалын ганцхан мөрийг чин сэтгэлээсээ талархан хүлээж авсан хүн түүнийгээ хэрэгжүүлэхэд өөрийгөө бүрэн зориулдаг. Тийм хүнтэй учирсан эргэн тойрны хүмүүс нь ч гэсэн адилхан сургаалыг чин сэтгэлээсээ хэрэгжүүлдэг. Ийнхүү эргэн тойрны хүмүүс нь бүгд буяныг хүртээд ирэхээр баярлаж талархахгүй байхын аргагүй болдог.

Цагаан цайлган сэтгэлээр сургаалд хандан баярлах уу, дүрэм журам ярьсаар байгаад хэрэгжүүлэхээ хойш нь тавих уу гэдгээс тэнгэр газар шиг ялгаа үүсдэг.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, 56-57х

Living the Lotus  
Vol. 142 (2017.07)

**Хэвлэсэн:** Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

**Хаяг:** Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

**TEL:** +81-3-5341-1124

**FAX:** +81-3-5341-1224

**Email:** [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)

**Ахлах редактор:** Мизүтани Шёокоо

**Орчуулсан:** Б.Мөнхцэцэг, Ж.Гэрэлтуяа

**Эхийг хянасан:** Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба "Турван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар"-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)" хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*

## Бусдыг хүлээн зөвшөөрч магтах

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### “Амь нас”-ыг хүндлэн магтах

Хүний мундаг, сайн талыг магтахад юутай харицуулж “мундаг” гэж тодорхойлдог юм бол?

Бодит амьдрал дээр бид онц сурдаг, ажилд сайн, зан чанар, бие бялдрын хөгжил сайтай гэх мэт сайн талыг нь заан “мундаг” гэцгээж, тухайн хүнийг хүлээн зөвшөөрч магтдаг.

Гэтэл Шагжамүни будда өөрийнх нь амийг хөнөөх гэсэн Дэвадатыг “сайн анд” хэмээн магтаж, алуурчин Ангулималаг шинээр дахин төрнө гэдэгт итгэж шавиа болгосон гэдэг.

Энэ нь нийгмийн ерөнхий чиг хандлагаас өөр байж магадгүй ч, үүнд хүнийг хүлээн зөвшөөрч, магтахтай холбоотой чухал зүйл нуугдаж байгаа гэж бодож байна.

“Магтах” гэдгийг шууд утгаар нь аваад үзэх юм бол өөрийг нь хороох гэсэн хүнийг магтана гэдэг байж боломгүй зүйл. Харин буддизмд “магтах”-ыг “бурхан, бодисадвагийн ач буян, чадварыг магтах” гэсэн утгатай гэж заадаг. Энэ утгаар нь аваад үзвэл Шагжамүни будда хичнээн нүгэл ихтэй хүнийг ч гэсэн магтахаа мартаагүй нь тухайн хүний бурханлаг, бодисадвалаг талыг нь олж хардаг байснаас гарцаагүй.

Мэдээж хэрэг хүнийг үнэлж дүгнэхэд тухайн хүний үйл хөдлөл, үг хэл, зан чанарыг харах чухал. Гэвч зөвхөн түүгээр нь хэмжиснээр угийн байдаг бурханлаг чанар хэмээх чухал зүйлийг мартчих гээд байдаг талтай. Бурханы номд суралцаж байгаа бидний хувьд хүнийг хүлээн зөвшөөрч, магтах гэдгийг “амь нас”-ыг хүндлэн магтах гэж ойлгож болно.

Бодит байдал дээр тэр хүртэл олж анзаарах хэцүү байдаг. Гэхдээ л жишээ нь эцэг эхчүүд хүүхэддээ хандахдаа, дарга нь ажилтнаа үнэлж дүгнэхдээ, эсвэл найзуудтайгаа харилцахдаа мундаг талыг нь олж харахыг хичээж, угтаа бид бүгдээрээ бурхан, бодисадватай адилхан “амь нас”-ыг хүртсэн байдаг гэдгийг мартаж болохгүй гэж бодож байна.



## Гоё ганган үгээр биш

Магтах сайшаах тухайд сүүлийн үед ялангуяа техник, арга барил болгон ашиглах явдал дэлгэрч, ажиллах хүчин бэлтгэх, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх заавар зөвөлгөөний материал “магтах” гэдэг үгээр дүүрчээ. Магтахын чухлыг тайлбарлахдаа Эдогийн үеийн Жиүн ламтны “хийж үзүүлж, хэлж өгч, хийлгэж үзүүлж, магтаж өгөхгүй бол болохгүй шүү” хэмээх алдартай үгийг ихээр ашигладаг. Дээрх үгийг сайтар унших юм бол заах хүн нь ч, заалгах хүн нь ч аль аль нь өсөж хөгждөг гэсэн чухал зүйлийг илэрхийлдэг.

Хүнийг магтах гэдэг нь өөрийнхөө сэтгэлийг нээх гэсэн үг. Зөрүүд гөжүүд хүний хувьд магтах чухал гэж хэлсэн ч гэсэн тэр чигээрээ зөрүүдлээд байх юм бол магтаалын үг ганц ч гарч ирэхгүй. Сэтгэлээсээ бусдыг хүлээн зөвшөөрч, магтаснаар хүмүүстэй ойлголцож, зөөлөн уур амьсгал бий болдог. Энэ утгаараа хүнийг хүлээн зөвшөөрч, магтах нь үнэндээ бусдын төлөө биш өөрийнхөө сэтгэлийг өнгөлөн зүлгэх үйлийн нэг гэж хэлж болох юм.

1965 онд байсан байх аа. Би тухайн үед сэтгэлдээ янз бүрийн асуудал тээж байсны дээр анх удаа мацаг барихаар болсон юм. 8 өдрийн бүтэн мацаг болон хоолоо аажмаар багасгаж, ихэсгэх үе шат дуусч, гэртээ хариад усанд орж байтал аав /Үүсгэн байгуулагч/ гэнэт орж ирэв. Тэгээд “нурууг чинь угааж өгье” гээд турж эцсэн миний нурууг угаангаа “нуруу чинь гялалзаж байх чинь” хэмээн магтаалын үг гэхэд хэцүү үг хэлсэн юм.

Энгийн нэг эцэг хүүгийн харилцан яриа байсан хэдий ч, бидний хувьд ховорхон тохиолдох үйл явдал байж билээ. Тэр мөчийг бодохоор хүнийг хүлээн зөвшөөрч, магтахад юу чухал болохыг жоохон ч гэсэн ойлгоод байх шиг санагддаг. Магтана гэдэг нь гоё ганган үг хэлэх биш, бусдын амь насыг нандигнан хүндлэх, чин сэтгэлээсээ амжилт хүсэх сэтгэлийг хэлдэг юм болов уу.

“Косей” сэтгүүл 7-р сарын дугаараас



## Миний дотор орших бурхан

Шриланк нийгэмлэг  
Каранде Канканамге Малини Алвис

*Энэхүү илтгэл 2016 оны 11 сарын 15-нд Их Ариун ордонд зохион байгуулагдсан  
Үүсгэн байгуулагчийн мэндэлсэн өдрийн ёслол дээр тавигдсан болно.*

Та бүгдэд энэ өдрийн мэнд дэвшүүлье. Намайг Малини Алвис гэдэг. Энэтхэгийн өмнөд хэсэгт орших арлын улс Шриланкаас ирсэн. Гэрлээд 31 жил болж байгаа ба нөхөр маань гэр бүлээ сэтгэлээсээ хайрлаж, хамгаалдаг ажилч хичээнгүй сайн хүн. 29 тэй хүү маань энэ жил хүнтэй гэрлэсэн. Охин маань 27 настай. Ингээд манай гэр бүл нөхөр, би, хүү, бэр, охин, 1 нохойтойгоо цуг амьдардаг.

Миний бие Шриланк нийгэмлэгт гэр сүмийн лидер, гэр бүлийн боловсролыг дэмжих ахлагч, түүнчлэн Шриланк улсын засгийн газарт бүртгэлтэй Рисшо Дарма байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүргийг тус тус гүйцэтгэж байна.

2010 онд Ямамото тэргүүн Шриланк сүмийн тэргүүнээр томилогдож ирсэн. Ямамото тэргүүн Нивано ерөнхийлөгчийн сүүлийн 20 жилийн турш айлдсан “зүрх сэтгэлээ сайжруулах” сэдэвтэй “бурханы сургаал бол баттай үнэн”, “бидний дотор бурхан багшийн нандин амь нас амьдарч байгаа” зэрэг сургаалуудыг бидэнд дамжуулсан.

Шриланкт төрж өссөн, буддын бага



*Их Ариун ордонд илтгэл тавьж буй  
гишүүн Каранде Канканамге*

хөлгөний сургаал номын уламжлалаар хүмүүжсэн миний хувьд өөрийн дотор бурханы амь нас оршиж байгаа гэдэгт итгэхэд бэрх байв. Гэвч одоо бол миний бодол өөрчлөгдсөн ба сүсэг бишрэлээ гүнзгийрүүлж, сургаалыг хэрэгжүүлж байна.

Би 1996 онд РКК-д гишүүнээр элссэн. Нөхрийн найз Гамини Чандрасэкэра намайг анх “Японы байгууллага юмаа, нэг очоод үзээч” гэж урьсан. Сахил хүртсэн лам хүн байхгүй гэдгийг дуулаад жаахан эргэлзсэн ч нөхрийн маань найз урьсан тул татгалзаж чадалгүй очсон. Гэвч анх удаа очсон надад гишүүд хоорондын халуун дулаан уур амьсгал, мөн бие биедээ хүндэтгэлтэй алга хавсран залбирч байгаа нь гүн сэтгэгдэл төрүүлэв. Түүнчлэн бусад хүмүүс өөрсдийн эцэг эх, өвөг дээдэстээ талархаж байгаа нь их таалагдсан.

Шриланкад сар бүрийн бүтэн сартай өдрийг Пояа өдөр гэж нэрлээд нийтээрээ амардаг уламжлалтай. Тэгээд бурханы шашинтан хүмүүс сүмд очиж мөргөл үйлддэг. Харин миний хувьд РКК-н Пояа өдрийн үйл ажиллагаанд оролцдог болсон.

Хэдэн жилийн өмнөөс Зүүн өмнөд Азийн хариуцагч асан Сайто гуайн хүчин зүтгэлээр Токиогийн гэр бүл судлалын институцийн багш нар Шриланкад ирж гэр бүлийн боловсролын талаарх хичээл заадаг болсон. Тэр сургалтанд сууснаар хүүхдээ өөрийн санасны дагуу л байлгах гээд байдаг байснаа анзаарч, өөртөө дүгнэлт хийсэн. Гэр бүлийн сургалт нь “бусдын дотор орших бурханыг нь олж харж, залбирах” гэсэн Цагаан лянхуан сургаалын үндсэн агуулгатай ижил гэдгийг ойлгосон. Одоо Шриланкийн олон эцэг эхчүүдэд тус сургалтыг таниулан хүргэхээр хичээж байна.

2015 оноос Шриланк нийгэмлэгээс “гэр төвтэй сүм” гэсэн үйл ажиллагааг зохион байгуулж эхлэв. Бурханаа гэртээ залсан ямар ч



гишүүн өөрийн хүсэлтээр гэртээ цуглаан зохион байгуулах боломжтой. Гэртээ хамаатан садан, найз нөхдөө цуглуулаад РКК-н сургаалаас суралцах хоозаг хийж болно. “Гэр бүлийн бүх гишүүдийн доторх бурханд нь залбирья” хэмээх сэдэвтэй. Миний бие ч өөрийн хүсэлтээр “гэр сүмийн лидер”-н үүргийг хүлээн авсан. Ийнхүү би хамаатан, найз нөхөд, хөршүүд, танилууддаа гэртээ болох үйл ажиллагаанд оролцохыг идэвхтэй санал болгож байв. Тэр дотор 30 жилийн өмнөөс таних бүсгүй байв. Тэр бүсгүй нөхөр, 3 хүүгийн хамт амьдарч байсан боловч нөхөр нь мотоциклийн ослоор гэнэт нас барж, түүнээс ердөө 5 сарын дараа эцэг нь өвчний улмаас хорвоог орхисон юм. Тэр бүсгүйд ах дүү байхгүй тул 15, 9, 1 настай 3 хүү болон бие муутай ээжийгээ харж хандах том хариуцлага ирсэн юм. Эзэгтэйн үүргийг олон жил гүйцэтгэж ирсэн түүнд орлого байсангүй. Ар араасаа цуврах гачигдалд сэтгэл санаа нь үймэрч, хөвгүүддээ хүртэл муу зүйл тохиолдох вий дээ гэж санаа зовж, мөн аавынхаа барьсан байшин нурж унах вий гэх зэргээр санаа зовох зүйл их байлаа. Түүнчлэн бие муутай ээжийнх нь арчилгаа сувилгаа түүнд том ачаа болж байв.

Тэрээр амьдарч байсан байшингаа бусдад түрээслүүлж, өөрсдөө жижиг байр түрээслэв. Гэтэл хамаатан садан нь яасан ээжийгээ боддоггүй юм, яагаад ийм жижиг байр луу нүүж байгаа юм зэргээр түүнийг буруутгах хүн олон байлаа. Түүнд энэ бүхэн хүндээр туссан боловч сэтгэлээ нээж ярих хүн олдохгүй байсан тул нэг өдөр намайг зорин ирсэн. Түүний яриаг анхааралтай сонслоо. Ээжийнхээ сувилгааг чадлаараа хийж байгаа боловч ээжид нь ямар ч талархал байдаггүй, мөн амьдралд нь ямар ч туслалцаа үзүүлдэггүй хамаатнууд нь хааяа нэг ирэхээрээ түүнийг байнга шүүмжилдэг талаар тэр бүсгүй бухимдангүй яриу.

Би түүнийг дагуулан Ямамото тэргүүн дээр очив. Тэргүүн бүсгүйд хандан: “чиний яриаг сонсоход чи төрүүлж өсгөсөн ээжийгээ чин сэтгэлээсээ хайрладаг бөгөөд сэтгэл гарган арчилж сувилахыг хүсдэг чинь мэдрэгдэж байна. Гиймээс өөрийн чин сэтгэлийн хүслээ дагаж, ээждээ талархалтай хандах хэрэгтэй. Мөн санаа зовнин ирэх хамаатнууддаа ч гэсэн талархах

хэрэгтэй” гэсэн зөвлөгөөг өгөв. Түүнчлэн тэргүүн надад хандан “ямар ч хүнд хэцүү үед бурханд итгэхээ больж болохгүй, Мали та энэ бүсгүйн доторх бурхан нь гэрэлтэж байна гэж мэдрэх хүртлээ доторх бурханд сүсэглэж, бүсгүйн төлөө тэдоригоо үргэлжлүүлэх хэрэгтэй” гэж зөвлөв.

Би тэргүүний зөвлөгөөг дагаж, нэгэн сэтгэлээр тэр бүсгүйн доторх бурханд нь залбирав. Гэтэл гайхалтай нь тэр бүсгүй яг тэргүүний хэлснийг хэрэгжүүлж эхлэв. Би үнэхээр гайхсан боловч тэргүүний мэдэрсэн “ээжийгээ хайрлан асармаар байна” гэсэн бүсгүйн сэтгэл бол түүний доторх бурхан юм байна гэдгийг ойлгов. Бүсгүйн сүсэглэх сэтгэл үнэхээр хүчтэй байв. Удалгүй гэрт нь бурхан залж, өглөө орой судраа уншдаг болов. Гайхалтай нь тун удалгүй удаан хугацааны турш зарагдахгүй байсан тэдний байшинг худалдаж авах хүн гарч ирэв. Ингэснээр бүсгүйн хувьд амьдралд нь гэрэл нэмэх шиг болж, гэр бүл нь ядуу тарчиг амьдралаас аврагдсан юм. Мөн 17 настай дунд хүүд нь сургуулиас нь санал тавьж, Хятад руу явж сурахаар болов. Дунд хүү нь Хятад руу яваад удаагүй байхад удаан хугацаанд өвчнөөр шаналсан бүсгүйн ээж нас барав. Ээж болон дүү нараа тэжээхийн тулд ажиллаж байсан том хүүд нь ч Хятадад тэтгэлэгтэй сурах боломж олдсон юм. Том болон дунд хүү нь Хятадад сурч байгаа учир мөнгө явуулах боломжгүй ч хоёулаа цагийн ажил хийж, ээжээсээ тусламж авалгүй өөрсдийгөө болгон амьдарч байгаа. Хэдэн жилийн дараа хөвгүүд нь Синхала хэл, Хятад, Англи хэлтэй мундаг боловсон хүчин болоод буцаж ирээд нутаг орондоо ажиллаасай гэж би байнга залбирдаг. Тэргүүний хэлсэн “доторх бурханд нь итгээд, залбирах” үйл нь авралын үндэс болдог гэдгийг би тэр бүсгүйн тэдоригоор дамжуулж ойлгосон юм.

Би РКК-д элсэн ороод 20 жил болж байгаа ба 11 сарын 1-нд Ямамото тэргүүнээс Их Ариун ордонд илтгэл тавих үүрэг хүлээн авснаа дуулаад үгээр илэрхийлэхийн аргагүй их баярласан. Учир нь Японы олон номын андуудаасаа маш их туслалцаа, нигүүлсэлийг хүртсэндээ, мөн энэ гайхалтай сургаалыг

айлдсан Үүсгэн байгуулагч, ерөнхийлөгчид талархлаа илэрхийлэх боломж олдож байгаа болохоор юм.

Энэ оны 8 сарын 23-ны үдээс хойш 7 хагасын үед хүүгийнхээ машинд суугаад явж байтал, гэнэт хурдны замын хашлагыг мөргөж, машин нь хажуугаараа эргэж орхисон. Арын суудалд сууж явсан би ууц болон хоёр хөлний суурь ясандаа цууралт авч, хүндээр гэмтэв. Нас барсан аавынхаа хойдхын буянд зориулж хамаатнуудаараа нийлж, 318 ортой эмнэлэгийн өвчтөнүүдэд оройн хоол хийгээд хүргэж өгчихөөд буцаж явах замд ийм осолд орж орхисон юм. Жолоо барьж явсан хүү маань ядарсан бололтой, зүүрмэглэсэн байв. Машин нь авах юмгүй болсон ч азаар хүү ч тэр хажуугийн суудалд нь сууж байсан бэр маань ч огт гэмтэж бэртээгүй. Замын цагдаа “энэ хурдны замд осолд ороод амьд гарсан хүн байгаагүй” гэж хэлснийг нөхөр маань надад дараа нь хэлсэн юм. Үнэхээр бурханы хамгаалалд багтжээ гэж бодогдож байна. Гишүүн биш хамаатан маань хүртэл надад “Мали чи өдөр бүр РКК-н сургаалыг хичээнгүйлэн хэрэгжүүлж байгаа болохоор энэ зэргийн бэртэлтэй өнгөрсөн байх” гэж хэлсэн. Ганцхан хүү маань л яагаад хамгийн их бурханы сургаалыг хэрэгжүүлж дагадаг ээж маань ингэтлээ бэртдэг байнаа гэж хэлсэн гэсэн. Хэрэв

энэ ослоор хүү, бэр хоёрт маань ямар нэг зүйл болсон бол би амьд явж чадахгүй байх байсан. Бурхан багшийн билэг оюун тунгалаг тул тэр бүгдийг сайн мэдээд, ганцхан намайг бэртэлтэйгээр ослын амыг хаасан байх. Үнэхээр талархаад баршгүй.

Эмнэлэгийн орон дээр хэвтэж байхдаа би илтгэл тавих үүргээс татгалздаг ч юм билүү гэж бодсон. Гэвч Шриланк нийгэмлэгээ төлөөлж, бурханаас хүртсэн хүндтэй үүрэг болохоор юу ч тохиолдсон талархан гүйцэтгэе гэж сэтгэлдээ шийдэж, Япон луу явахаар болов. Дараа жил Шриланк нийгэмлэг шинэ өргөөний нээлтээ хийж, Ялж Төгс Нөгчсөн Бурханаа залах болно. Шриланкийн гишүүд бидний хувьд шинэ өргөө маань ариун газар тул тэсэн ядан хүлээж байна.


Ослоор би амьг насаа алдаж болох байсан. Одоо ийнхүү амьд байгаа маань бурхан багшаас хүртсэн амьг нас юм. Нивано ерөнхийлөгчийн айлддаг “Язгуурын бурхан хийгээд сургаал ном бол ямар ч худал хуурмагийг агуулаагүй, баттай үнэн” гэсэн сургаалд итгэн, хүртсэн амьг насаа Цагаан Лянхуан сургаал номыг дэлгэрүүлэх ариун үйлсэд зориулахаа тангараглаж байна. Анхаарал тавин сонссон Японы номын андууддаа баярлалаа.



*Гэр бүлийн боловсрол олгох сургалтын бэлтгэл хурал( зүүн гар талд гишүүн Алвис, баруун гар талд гишүүн Сдажинха)*

**Living the**

**LOTUS**



## 8-р ангийн охин маань үгэнд орохоо болилоо



8-р ангид сурдаг охин маань зөрүүдлээд байх боллоо. Гар утас зээлээр худалдаж аваад үргэлж мессеж бичихээс гадна оройтож ирнэ. Мөн бидний өгч байгаа хэрэглээний мөнгөнөөс илүү үнэтэй юм аваад байх шиг санагдах боллоо. Өрөөгөө талаар нэг тараачихна. Цэвэрлэ гэхээр “Ямар үглээ юм бэ” гэхээс биш ер үг дуулахгүй. Ширүүхэн хэлсэн ч гэсэн эсэргүүцнэ. Яаж харилцвал дээр вэ?




Хүүхэд дунд ангид орохоороо сэтгэлзүйн хувьд эхийн сүүнээс гарах үе дээрээ ирдэг. Хүүхэд шиг харьцахад дургүйцэж, өөрөө бодож, харж сэтгэхийг эрмэлздэг. Тиймээс эцэг эхийнхээ албадлага, хувийн асуудалд нь оролцох, түрэмгийлэх зэргийг хүчтэй эсэргүйцдэг. Ширүүн хандах тусам сэтгэл нь эсрэг тийш эргэдэг.

“Биеэ дааж, өөрийн хүчээр амьдаръя” гэсэн сэтгэл нь том хүн болох эхний алхам учраас хүүхдийнхээ сэтгэлийг хүндэлж, ээж нь тайвнаар охиныхоо өөрчлөлтийг хөндлөнгөөс харж хамгаалах хэрэгтэй. Гар утас, оройтож ирдэг, хэрэглээний мөнгө, өрөөний байдал гээд бүх зүйл дээр та зөвхөн өөрийнхөө үзэл бодлыг тулгаагүй эсэхээ эрэгцүүлэн бодоод үзээрэй. Тэгээд охиндоо “Яасан бэ, уг нь чи ийм байдаггүй дээ. Ямар нэг зүйлд шаналаа юу” гэхчилэн эхлээд охиноо сайтар сонсож, сэтгэлийг нь ойлгон хуваалцаж, хүүхдийнхээ төлөвлөгөө, үзэл бодлыг хүндлэх чухал.

Энэ нь мэдээж хүүхдийнхээ хэлснээр бай гэсэн үг биш. Хүүхдийнхээ сэтгэл санааг сайтар ойлгосны үндсэн дээр өөрийн сэтгэл болон санал бодлыг хэлж харилцан ойлголцох хэрэгтэй. Ойлгох гэдэг нь “санаа нэгдэн нэг зүг рүү алхах” гэсэн утгатайгаас гадна ондоо талаа харилцан ойлголцох гэсэн утгатай. Тэгэхээр эцэг эх нь харин ч хүүхдийнхээ үзэл бодлыг хүлээн зөвшөөрч, харж хандан, тусалж дэмжих байр суурьнаас хандах хэрэгтэй. Ойлголцоод

ирэхээр харилцан нэгнийхээ байр сууринаас бодож, биесээ гэсэн сэтгэлээр харицаж чадна.

“Үглээ” гэж хэлж байгаа бол таны хэлж анхааруулах их болоод тээртэй байгаа юм болов уу гэж бодогдож байна. Цөөн үгтэй байж, хүүхдээ ойлгохыг хичээвэл түүнийг охин тань заавал мэдэрнэ. Өөрийг нь хувь хүн гэдэг талаас нь хүлээн зөвшөөрч, итгэж найдаж байгааг ойлгохоороо хүүхэд өөрөө ч гэсэн бусдыг хүндэлж хайрладаг хүн болон өсч төлөвшдөг.



### Point

Дунд ангийн насны хүүхэд ирээдүйд ямар хүн болохоо тодорхойлж, өөрийгөө хүндлэх сэтгэл нь ихсэж, түүнийгээ хүлээн зөвшөөрүүлэх гэсэн хүсэл нь хүчтэй болж ирдэг. Ямар нэг талаар өөрийг нь хүлээн зөвшөөрөхийг хүсэж, түүнийгээ янз бүрийн байдлаар илэрхийлдэг. Энэхүү эсэргүүцэх үеийг үзэл бодол сэтгэлзүйн хувьд өсч төлөвших үе хэмээн хүлээн авч, харилцах нь чухал.

Токио гэр бүлийн сургалт, судалгааны институт

Токио гэр бүлийн сургалт, судалгааны институт нь “Эцэг эх өөрчлөгдөх юм бол хүүхэд ч гэсэн өөрчлөгдөнө” гэсэн сурган хүмүүжүүлэх арга ухаанд тулгуурлан газар газарт сургалт семинар зохион байгуулж, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх талаар зөвөлгөө өгч байна. Үүгээр дамжуулан олон хүмүүс хүүхдээрээ дамжуулан гэр бүл гэж ямар байдгийг суралцаж, аз жаргалтай гэр бүл олноор төрж байна.



## Амь насыг хүндлэхээ мартахгүй байх

Охин тань шилжилтийн насан дээрээ ирчихээд бие сэтгэлийн хувьд тогтворгүй байгаа юм байна. Гэхдээ үүгээр дамжуулж охин тань нэг, хоёр дахин өсөж хөгжин хүчтэй болно.

Тийм үед эцэг эх нь хэрхэн харж хамгаалах хэрэгтэй юм бол? Энэ талаар РКК нийгэмлэгийн ерөнхийлөгч ийнхүү сургасан байдаг.

“Эцэг эх нь бурханы номыг ухамсарлаж, үргэлж талархах сэтгэлтэй байвал хүүхэд нь өөрийн мэдэлгүй янз бүр авирласан ч тайвнаар хүлээн авч чаддаг. Бас хүндлэх сэтгэлээ мартахгүй байж чадна. Хүүхэд эцэг эхийнхээ тэр байдлаас гүн итгэлийг олж авч, сэтгэлээ нээн, шаналж байгаа зүйлээ илэн далангүй илэрхийлдэг болдог.1

Охин тань 8-р анги юм бол ээж нь ч гэсэн ээж болоод 8-р анги болж байгаа гэсэн үг. Охиныхоо сэтгэл санааны тогтворгүй байдлыг ойлгож, бурханаас заяасан охиныхоо амь насыг хүндлэн мөргөж, охинтойгоо харилцах харилцаагаар дамжуулан өөрөө суралцаад явбал ямар вэ?

1. “Нэг хөлгөн товхимол” Х43, 7-9 мөр

РКК, Сургалтын алба



Please give us your comments!



We welcome comments on our e-newsletter Living the Lotus.

E-mail: [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)

## Өөрийн болон бусдын дотор орших бурханд мөргөх

Өнгөрсөн 6 сарын 4-нд РКК Шриланк нийгэмлэгийн шинэ өргөөний нээлтийн ёслол Шриланкын томоохон хот Коломбын захад болж өнгөрлөө. Буддын Бага хөлгөний уламжлалаараа танигдсан Шриланк улсад Их хөлгөний Язгуурын Буддаг залж, шинэ өргөөтэй болсон нь тус нийгэмлэгийн тэргүүн Ямамото болон гишүүдийн нөр их хөдөлмөрийн ач гавьяа билээ.

Ямамото тэргүүн 2010 онд Шриланк нийгэмлэгийг хариуцсан цагаасаа хойш “өөрийн болон бусдын дотор орших бурханд мөргөцгөө” хэмээн гишүүддээ айлдаж ирсэн. Гэвч Бага хөлгөний сургаалд Бурхан гэдгийг зөвхөн туйлын эрхэм дээд Шагжамүни будда гэж үздэг тул гишүүд анхандаа тэр эрхэм дээд зүйл өөрийн дотор байгаа гэдэгт итгэхгүй байжээ. Гэсэн хэдий ч тэргүүн 8 жилийн турш сургаалаа айлдаж, өөрөө ч хэрэгжүүлснээр гишүүд одоо өөрийн доторх бурханыг мэдэрч, бусдын доторх бурханд мөргөдөг болсон байна.

Шинэ өргөөний нээлтийн ёслолоор дамжуулан Шриланк гишүүдийн бурханлаг чанарт мөргөж буй цагаан цайлган дүр төрх болон халин буй баяр хөөрийг хараад миний сэтгэл маш ихээр хөдөлсөн юм.

РКК, Олон улсын хэлтсийн дарга  
Мизүтани Шёокоо

